



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2024 оны 10 сарын 25 өдөр

Дугаар 543

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6.2.1, 6.4.1, 6.4.2, 6.4.3, 6.4.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Кибер халдлага, зөрчилтэй тэмцэх нийтийн төв” улсын төсөвт үйлдвэрийн газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй ашиглалтын хугацаа дууссан, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, засаж сэлбэн ашиглах боломжгүй 10 нэрийн, нийт 443,861,000.00 (дөрвөн зуун дөчин гурван сая найман зуун жаран нэгэн мянга) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2. “Кибер халдлага, зөрчилтэй тэмцэх нийтийн төв” улсын төсөвт үйлдвэрийн газрын захирал Ч.Золбаярт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан хөрөнгийг акталж, данснаас хасах, сэлбэгээр ашиглах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2025 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

Д.НАРАНГЭРЭЛ



132002428
23-r huraldaah.docx



Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын
2024 оны 11 дугаар сарын 15-ны өдрийн
543...дугаар тогтоолын хавсралт

"КИБЕР ХАЛДАГА, ЗӨРЧИЛТЭЙ ТЭМЦЭХ НИЙТИЙН ТӨВ" УЛСЫН ТӨСӨВТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨД
БҮРТГЭЛТЭЙ, АКТАЛЖ ДАНСНААС ХАСАХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

№	Үндсэн хөрөнгийн нэр, марк	Ашиглалтад орсон огноо	Тоо хэмжээ	Хэмжих нэгж	Нэг бүрийн үнэ (төгрөг)	Балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэгдэл өртөг (төгрөг)
1	Олон антивирусын энжийн нэгтгэсэн платформын лиценз	8/10/2023	1	Ширхэг	21,985,700.00	21,985,700.00	0.00
2	Программ хангамж: Кибер аюул заналын мэдээллийн систем /Cyber Threat Intelligence/ лиценз DeCYFIR	8/10/2023	1	Ширхэг	119,077,200.00	119,077,200.00	0.00
3	Программ хангамж: Сүлжээний нэвтрэн шалгалт /Penetration Testing/ хийх багажны лиценз /Tenable Nessus Expert/	8/10/2023	1	Ширхэг	29,599,900.00	29,599,900.00	0.00
4	Программ хангамжийн нэвтрэн шалгалт /Penetration Testing/ хийх багажны лиценз Burp Suite professional Pro License	8/10/2023	1	Ширхэг	74,415,000.00	74,415,000.00	0.00
5	Программ хангамж: Фишингийн үнэлгээний багажны лиценз /Phishing Assessment tool/ Hook security	8/10/2023	1	Ширхэг	22,059,400.00	22,059,400.00	0.00

№	Үндсэн хөрөнгийн нэр, марк	Ашиглалтад орсон огноо	Тоо хэмжээ	Хэмжих нэгж	Нэг бүрийн үнэ (төгрөг)	Балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэгдэл өртөг (төгрөг)
6	Программ хангамж: Хортой кодын шинжилгээний багажны лиценз /Malware analysis tool/ Joy Sandbox Ultimate License	8/10/2023	1	Ширхэг	61,070,900.00	61,070,900.00	0.00
7	Программ хангамж: Reverse engineering tool/Hex-rays IDA Pro	8/10/2023	1	Ширхэг	16,412,000.00	16,412,000.00	0.00
8	Программ хангамж: Ticketing sestym/Jira	8/10/2023	1	Ширхэг	6,373,400.00	6,373,400.00	0.00
9	Программ хангамж: Виртуал хувийн сүлжээ/VPN/ open VPN	8/10/2023	4	Ширхэг	944,625.00	3,778,500.00	0.00
10	All based security tool /Jfrog X-Ray	8/10/2023	2	Ширхэг	44,544,500.00	89,089,000.00	0.00
			14		396,482,625.00	443,861,000.00	
	Нийт дүн				396,482,625.00	443,861,000.00 (дөрвөн зуун дөчин гурван сая найман зуун жаран нэгэн мянга)	